

ҮАГ-ЫН ХАРЬЯА СЭЛЭНГЭ АЙМГИЙН АУДИТЫН ГАЗАР



**СЭЛЭНГЭ АЙМГИЙН ЕРӨӨ, БАЯНГОЛ, АЛТАНБУЛАГ СУМЫН
ИРГЭДЭЭС ИРҮҮЛСЭН ӨРГӨДЛИЙН ХАРИУ**

Товчилсон үгийн тайлбар	
МУ	Монгол улс
ТББ	Төрийн бус байгууллага
ТБОНӨБАҮХАТХ	Төрийн болон орон нутгийн өмч хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
ИНХ	Иргэдийн нийтийн хурал
БСШУЯ	Боловсрол соёл шинжлэх ухааны яам
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
ЗГ	Засгийн газар
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
УИХ	Улсын их хурал
ТСТ	Төрийн сангийн төлөөлөгч
ЭМТ	Эрүүл мэндийн төв
ТӨХ	Төрийн өмчийн хороо
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
ЕБС	Ерөнхий боловсролын сургууль

Сэлэнгэ аймгийн Ерөө, Баянгол, Алтанбулаг сумын иргэдээс МУ-ын Ерөнхийлөгчийн Тамгын газарт хандан ирүүлсэн өргөдөл, Алтанбулаг сумын “Алтанбулаг-Итгэл” ТББ-ын тэргүүн В.Ганболд, захирал Ц.Болормаа нараас Сэлэнгэ аймгийн Аудитын газарт ирүүлсэн өргөдлийн дагуу дээрх сумдад ОНХС-гаас болон улс, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаас санхүүжүүлсэн төсөл, арга хэмжээний гүйцэтгэл, өмч хувьчлал, байгаль орчны нөхөн сэргээлт, дулаан хангамжийн асуудлууд, тэдгээрт мөрдөгдөх хууль, тогтоомжийн хэрэгжилтийг Сэлэнгэ аймгийн Аудитын газрын аудитор Ц.Отгонбаяр шалгаж үзээд дараах дүгнэлтийг гаргав. Үүнд:

Нэг. Ерөө сум

1.1 Ерөө сумын Бугант тосгонд ОНХСангийн хөрөнгийг төлөвлөхдөө иргэдийн оролцоог хэрхэн хангасан бэ?

Бугант тосгон нь 2013 онд ОНХСангийн хөрөнгийн эх үүсвэрээр хийгдэх төсөл, арга хэмжээг төлөвлөхдөө багийн иргэдийн саналыг хэрхэн тусгасан талаар холбогдох баримт материалуудыг тулган шалгаж үзлээ.

Тус багийн ИНХ-ыг 2012 оны 12 дугаар сарын 12-ны 15 цагт тосгоны соёлын төвд зохион байгуулсан боловч МУ-ын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 23.10¹ дугаар зүйлд заасны дагуу багийн ИНХ-ын ирц бүрдээгүй байхад хурлыг хүчин төгөлдөр болсноор тооцож, эрэмбэлж баталсан саналуудыг Ерөө сумын ИТХ-д хүргүүлсэн байна. Үүнийг хүснэгтээр харуулбал:

д/д	Сум, багийн нэр	Багийн нийт өрхийн тоо	Хуралд оролцвол зохих иргэдийн тоо	Хуралд оролцогсдын тоо	Зөрүү
1	Ерөө сум Бугант тосгон	857	214	173	41

ИНХ-д 173 иргэн оролцсон гэх боловч иргэдийн нэрсийн жагсаалтыг гарын үсэг зуруулж баталгаажуулаагүй байв.

Ерөө сумын багийн Иргэдийн нийтийн хурал дээр Засаг дарга Д.Сэргэлэн нь ОНХСангийн зорилго, түүнийг хэрхэн зарцуулах тухай холбогдох хуулийн заалтууд болон сум орон нутгийн төр захиргааны зүгээс баримтлах бодлого, чиглэлийн талаар мэдээлэл өгчээ. Үүний дагуу иргэд саналаа хэлж, санал тус бүр дээр гар өргүүлэн тоолж, эрэмбэлэн багийн ИНХ-ын 2012 оны 9 дүгээр тогтоолоор 31 ажлыг батлан сумын ИТХ-д хүргүүлсэн байна.

Ерөө сумын ИТХ-ын 2012 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн 10-р тогтоолоор дээрхи 31 ажлаас 7 төрлийн 210.0 сая төгрөгийн ажил батлагджээ. Үүнийг хүснэгтээр харуулбал:

/ сая төгрөг/

№	Төсөл арга хэмжээний нэр	Төсөвт өртөг	Авсан санал
1	Хог тээврийн зориулалттай тээврийн хэрэгсэл	30.0	85
2	Бирбаз /онгоцон гүүр /	20.0	73
3	Халуун усны барилга	40.0	71

¹Баг, хорооны Хурлын хуралдаанд зөвхөн тухайн баг, хорооны сонгуулийн насны иргэн бүр оролцож болох бөгөөд хуралдаанд багт 4 өрх тутмаас, хороо, аймгийн төвийн сумын багт 20-30 өрх тутмаас тус бүр нэг хүн хүрэлцэн ирсэн тохиолдолд хүчинтэйд тооцно.

4	Хүүхэд хөгжлийн төвийн барилга	60.0	67
5	Гэр хорооллын тоглоомын талбай	7.0	49
6	Орон нутгийн телевиз, хэвлэл ажиллуулах	11.0	63
7	Бугант эмнэлгийн бохирын шугамын засвар	42.0	22
Нийт дүн		210.0	

Халуун усны барилгын ажлын зураг, төсөв нь 64.6 сая төгрөг болсон учир эх үүсвэр хүрэхгүй гэж үзэн 2013 оны 9 дүгээр сард Ерөө сумын ИТХ-ын 29-р тогтоолоор халуун усны барилга, хөвдөг гүүр гэсэн 2 ажлыг хасч, үүний дараа эрэмблэгдсэн 25.0 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий гудамжны гэрэлтүүлэг, 25.0 сая төгрөгийн өртөг бүхий Бугант тосгоны доторхи зам засварын ажлуудыг нэмж баталсан байна.

Дээрх ажлуудаас замын ажлаас бусад ажил бүрэн хийгдэж, хэрэгжсэн байна. Ерөө сумын Бугант тосгонд 2013 онд ОНХС-ийн хөрөнгөөр хийгдэх төсөл, арга хэмжээг төлөвлөхдөө иргэдийн саналыг авсан боловч ИНХ-д оролцсон иргэдийн нэрсийн жагсаалтыг гарын үсэг зуруулж баталгаажуулаагүй, хурлын ирц бүрдээгүй байхад хурлыг хүчин төгөлдөр болсноор тооцож, иргэдийн саналыг эрэмбэлж баталсан байна.

Хоёр. Баянгол сум.

2.1 Хадлангийн 1 га газрын үнэлгээг сумын ард иргэдээс асуулгүйгээр ИТХ-ын тэргүүлэгчдийн хурлаар хэлэлцэж нэмсэн гэж мэдээлсэн:

Баянгол сумын ИТХ-ын 2013 оны 9 дүгээр сарын 04-ны 36 тоот тогтоолоор хадлангийн талбайг эзэмшин ашиглаж байгаа өөрийн сумын малчин, мал бүхий иргэд, бизнесийн чиглэлээр хадлан өвс бэлтгэгчид, бусад сумын иргэн, ААНБ-аас хадлангийн зориулалтаар ашиглах байгалийн ургамлын хураамжийн хэмжээг нэмж батлан /Хавсралт 1-ээр харуулав/, хадлангийн талбайн эзэмшилт, ашиглалттай холбоотой харилцааг зохицуулж, хяналт тавьж ажиллахыг Засаг дарга Б.Энхбатад үүрэг болгосон байна. Үүний дагуу Засаг дарга Б.Энхбат 2013 оны 9 дүгээр сарын 16-нд А/154 тоот захирамж гарган, хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллажээ.

2.2 Ерөнхийлөгчийн сонгуулийн хуулийг зөрчиж, төсөл хөтөлбөрийн хүрээнд иргэдэд зээл олгосон боловч тодорхой үр дүн гараагүй, байнгын ажлын байранд зуучлагдсан иргэн байхгүй гэж мэдээлсэн:

Баянгол сум нь Бороо гоулд компаний хандивын хөрөнгөөр бүрдсэн “Бороо сан”-гийн эх үүсвэрээс иргэдэд төмс, хүнсний ногоо тариалахад зориулан жил бүрийн хавар “Итгэлийн зээл” нэрээр тодорхой хэмжээний зээл олгож намар нь төлүүлэх ажлыг хэвшил болгож хэрэгжүүлж иржээ.

Дээрх зээлийн хүрээнд 2013 оны 5 дугаар сарын 1-нээс 6 дугаар сарын 7-ны хооронд нийт 126 иргэнд 49.3 сая төгрөгийн зээл олгосноос 33.0 сая нь төлөгдөж, 16.3 сая нь эргэн төлөгдөх хугацаа хэтэрсэн байна. Зээлийг олгосон хугацаа нь 2013 оны ерөнхийлөгчийн сонгуулийн хугацаатай давхацсан бөгөөд энэ нь зөвхөн 2013 онд хийгдсэн ажил бус жил бүрийн 5,6 дугаар сард хийгддэг ажил байна. 2013 онд “Бороо сан”-гаас “Итгэлийн зээл”-ээс гадна өрхийн аж ахуй, үйлдвэрлэлийг дэмжихэд 60 иргэнд 196.9 сая төгрөг /2013 оны 5 дугаар сарын 20-ноос 11 дүгээр сарын 7-ны хооронд, үүний 80 хувьд нь 5,6 дугаар сард олгосон/, залуу гэр бүлийг орон сууцжуулахад 28 иргэнд 72.1 сая төгрөг /7 дугаар сарын 10-наас 15-ны хооронд/, сумын иргэдийн

эмчилгээ, сургалтын зардалд 19 иргэнд 12.5 сая төгрөгийн зээлийг /4 дүгээр сарын 30-наас 10 сарын 5-ны хооронд/ тус тус олгожээ.

2.3 Нөхөн сэргээлт нэрээр алт олборлосон боловч нутгийн иргэдийн саналыг аваагүй, гол ус ихээр бохирдсон ч малчид цөхөрч санал, бодлоо сумын удирдлагад илэрхийлэхээ больсон гэсэн:

Аймгийн МХГ, БОАЖГ, сумын засаг даргын зүгээс “Эрхсийн дамжлага” компанитай 2012 оны 4 дүгээр сард байгуулсан хамтран ажиллах гэрээний дагуу Баянгол сумын Баян багийн нутаг дэвсгэр Тариат хэмээх газарт нөхөн сэргээлт хийлгэж, хийсэн ажлыг 2012 оны 11 дүгээр сарын 14-ний өдрийн актаар “Нөхөн сэргээлтийн ажлыг стандартын дагуу хийсэн” гэж дүгнэн хүлээн авчээ.

2013 онд Баян багийн нутаг дэвсгэр Урт булгийн аманд Бүүргэнт ХХК-ний ашиглалтын лицензтэй талбайд тус компани хуулийн дагуу нөхөн сэргээлтийн ажлыг хийж гүйцэтгэсэн байна.

2.4 Эмнэлэгт нь түргэн тусламжийн машин байхгүй байхад Баянгол сумын засаг дарга Б.Энхбат иргэдээсээ асуулгүй албаны машинаа шинэчилсэн гэсэн:

2010 онд аймгийн хөрөнгө оруулалтын 24.0 сая төгрөгийн эх үүсвэрээр 1997 онд үйлдвэрлэгдсэн, саарал өнгийн, механик хөдөлгүүртэй Land cruiser-80 автомашиныг худалдан авч сумын ЗДТГ-ын хөрөнгөнд бүртгэжээ.

Аудитын явцад Баянгол суманд ажиллах үед Улаанбаатар хотод засварт өгсөн гэх үндэслэлээр уг машин байхгүй байсан бөгөөд сумын засаг даргын албан хэрэгцээнд Land cruiser-100 маркийн автомашин ашиглагдаж байлаа.

Одоо ашиглагдаж байгаа Land cruiser-100 маркийн автомашиныг шинээр худалдан аваагүй бөгөөд бүртгэлд байгаа Land cruiser-80 автомашинаар солих бодолтой байгаа, энэ тухай хүсэлтийг аймгийн ИТХ-д хүргүүлсэн, одоогоор шийдвэр нь гараагүй байна гэсэн тайлбарыг сумын Засаг дарга Б.Энхбат өгч байв.

Ажиглалтаар холбогдох байгууллагын шийдвэр гараагүй байхад сумын ЗДТГ-ын бүртгэлд буй автомашиныг сумын Засаг дарга дур мэдэн өөр машинаар сольж ашиглаж байгаа нь тодорхой байлаа.

Иймд сумын ЗДТГ-т бүртгэлтэй Land cruiser-80 автомашиныг холбогдох байгууллагын шийдвэргүйгээр бусдад шилжүүлснийг буцаах албан шаардлагыг сумын засаг дарга Б.Энхбатад хүргүүлэв.

Мөн тус сумын эмнэлэг автомашингүй гэсэн мэдээлэл нь үнэн бөгөөд Засаг даргын албан хэрэгцээний автомашиныг ЭМТөвийн үйлчилгээнд давхар ашиглаж байсан.

Бороо сангийн хөрөнгөөр 2013 онд эмнэлгийн хэрэгцээнд фургон маркын авто машин худалдан авч ашиглаж байгаа, сүүлийн 3 жилд ЭМЯ-нд хүсэлт тавьсаны дагуу 2014 онд тусгай зориулалтын автомашиныг улсын төсвийн хөрөнгө оруулалтаар шийдвэрлэхээр болсон гэж тайлбарлаж байв.

2.5 “Бороо Гоулд” ХХК-ийн 451.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар “Хүүхэд хөгжлийн төв”-ийн барилгыг барьж 2012 онд ашиглалтанд оруулах

байсан ч барилгын 2 давхарын тааз цөмөрч унасан, одоог хүртэл тодорхой арга хэмжээ аваагүй, төсөвлөгдсөн 451.0 сая төгрөг зарцуулагдаж дууссан гэсэн:

Бороо гоулд ХХК-ний хандивын хөрөнгийн эх үүсвэрээр 2011 онд баригдах, 321.0 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий Хүүхэд хөгжлийн төвийн барилгын зураг, төсвийг Улаанбаатар хотын “Даль жигүүр” ХХК-иар хийлгэн “Талхун арал” ХХК-тай 2011 оны 8 дугаар сарын 27-ны өдөр гэрээ байгуулан, 2011 онд 243.6 сая төгрөг, 2012 онд 113.4 сая төгрөг зэрэг нийт 357.0 сая төгрөгийг шилжүүлсэн, 2012 оны 2 дугаар сарын 01-нд хүлээлгэж өгөх гэрээтэй уг барилгын ажил өнөөг хүртэл ашиглалтанд ороогүй байна.



Хүүхэд хөгжлийн төвийн барилгын ажлын зураг төсөв хийх болон барьж ашиглалтанд оруулах ажлын гүйцэтгэгчийг нээлттэй тендерээр бус шууд гэрээ байгуулах аргаар Даль жигүүр, Талхун арал компаниудаар гүйцэтгүүлсэн, зураг, төсөв буруу хийгдсэн, улмаар уг барилга гэрээт хугацаанд ашиглалтанд ороогүй, ажлын явц, гүйцэтгэлийг харгалзахгүйгээр санхүүжилтийг хийж ирсэн зөрчил илэрсэн байна.

Сэлэнгэ аймгийн Аудитын газар нь 2013 онд “Уул уурхайн компаниудын хөрөнгийн эх үүсвэрээр байгуулсан “Сум хөгжлийн сан”-гийн үйл ажиллагааны үр дүн”-д хийсэн гүйцэтгэлийн аудитаар албан шаардлага хүргүүлсний дагуу барилгын ажлын зураг, төсвийг экспертизээр баталгаажуулан, гүйцэтгэгч Талхун-Арал ХХК-ийг шүүхэд шилжүүлсэн бөгөөд шүүхийн шийдвэр гараагүй байлаа.

2.6 2012 оны улсын төсөвт тусгагдсан 75 хүүхдийн цэцэрлэгийн барилгын ажил бүрэн зогссон, үүнд сумын Засаг даргын оролцоо байсан гэж мэдээлсэн:

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2011-2012 онуудад хэрэгжих, 350.0 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 75 ортой цэцэрлэгийн барилга угсралтын ажлын гүйцэтгэгчийг тухайн үеийн БСШУЯ сонгон шалгаруулж, 2012 оны 8 дугаар сарын 1-нд ашиглалтанд хүлээлгэн өгөх гэрээг “ВЕТ” ХХК-тай 2011 оны 6 дугаар сард байгуулжээ. Гэрээний дагуу гүйцэтгэгч ВЕТ компанид нийт төсөвт өртгийн 87.1 хувь болох 305.0 сая төгрөгийн санхүүжилтийг шилжүүлсэн атал санхүүжилт дутсан гэдэг шалтгаанаар уг барилгыг өнөөг хүртэл ашиглалтанд хүлээлгэж өгөөгүй байна.

Нийт санхүүжилтийн 87.1 хувийг авсан боловч гэрээт хугацаандаа ашиглалтанд оруулаагүй цэцэрлэгийн барилга нь УИХ-аас санхүүжилтийг нь хойшлуулсан, царцаасан барилгын жагсаалтанд ороогүй, санхүүжилт нь ч нэмж батлагдаагүй, цаашид хэрхэх нь тодорхой бус байна. Уг барилгын ажил сумын засаг даргын үйл ажиллагаатай огт хамааралгүй, тендерийг БСШУЯ зарлаж, гүйцэтгэгчийг

сонгон шалгаруулсан, явцын хяналт, санхүүжилтийг Сэлэнгэ аймгийн холбогдох байгууллагууд гүйцэтгэж ирсэн байна.



/ 305.0 сая төгрөгөөр хийгдсэн ажил /

Аймгийн Аудитын газар нь 2013 онд “Улс, орон нутгийн төсвийн хөрөнгөөр санхүүжүүлсэн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний хэрэгжилт, үр дүн”-д хийсэн гүйцэтгэлийн аудитаар гэрээний үүргээ ноцтой зөрчсөн “ВЕТ” ХХК-ийг хуулийн байгууллагад шилжүүлж, энэ асуудлыг шийдвэрлүүлэх зөвлөмжийг Сэлэнгэ аймгийн Засаг даргад хүргүүлсэн ч хэрэгжээгүй байна.

2.7 Баянгол сум 6000 хүрэхгүй хүн амтай ч төрийн нүсэр бүтэцтэй, ЗДТГ 38 ажилтан ажилладаг гэж мэдээлсэн:

Баянгол сумын ЗДТГ-ын бүтэц, орон тоог тулгаж үзэхэд 2013 оны төсөвт 22 орон тоо батлагдаж, батлагдсан орон тоогоор ажилласан байна.

МУ-ын ЗГ-ын 2009 оны 13 дугаар тогтоолыг үндэслэн гарсан аймгийн Засаг даргын 2009 оны 52 тоот захирамжаар сумдын ЗДТГ-ын бүтэц, орон тоог баталжээ. Уг захирамжаар Баянгол сумын ЗДТГ 18 орон тоотой ажиллахаар батлагдсан боловч УИХ-ын 2010 оны 23, Засгийн газрын 2010 оны 223 дугаар тогтоолыг үндэслэн гаргасан аймгийн Засаг даргын 2010 оны 311 тоот захирамжаар сум бүрт гурван орон тоо бүхий ХАА-н тасаг байгуулахаар шийдвэрлэсэн байна.

Мөн 2011 онд мэдээлэл технологи, хэвлэл мэдээлэл хариуцсан мэргэжилтэн гэсэн орон тоог нэмж баталсан бөгөөд 2013 онд яамдын бүтэц зохион байгуулалт өөрчлөгдсөнтэй холбоотойгоор нийгмийн бодлого, хөдөлмөр, халамж үйлчилгээ хариуцсан мэргэжилтний нэг орон тоог хоёр болгож салган, 2013 онд нийт 22 орон тоотойгоор ард иргэдэд төрийн үйлчилгээг хүргэж байна.

2.8 Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр санхүүжигдэж хэрэгжих төсөл, арга хэмжээг хуулийн дагуу зохион байгуулаагүй гэж мэдээлсэн:

Баянгол сум нь ОНХСангийн хөрөнгийн эх үүсвэрээр 2013 онд хийгдэх төсөл, арга хэмжээг төлөвлөхдөө багийн иргэдийн саналыг хэрхэн тусгасан талаар холбогдох баримт, материалуудыг тулган шалгахад:

2013 оны 1 дүгээр сарын 11-15-ны хооронд 1,2,3-р багийн ИНХ-ыг зохион байгуулсан бөгөөд МУ-ын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.10-т заасны дагуу багийн ИНХ-ын ирц бүрдээгүй

байхад хурлыг хүчин төгөлдөр болсноор тооцон, эрэмбэлж баталсан саналуудыг Баянгол сумын ЗДТГ-т хүргүүлжээ.

Хүснэгтээр хурлын ирцийг харуулбал

д/д	Сум, багийн нэр	Багийн нийт өрхийн тоо	Хуралд оролцвол зохих иргэдийн тоо	Хуралд оролцогсдын тоо	Зөрүү
1	Баянгол сум 1-р баг	520	130	115	15
2	Баянгол сум 2-р баг	582	146	118	28
3	Баянгол сум 3-р баг	480	120	65	55

ИНХ-д оролцсон иргэдийн нэрсийн жагсаалтыг гарын үсэг зуруулж баталгаажуулсан байна. Сумын засаг даргын захирамжаар томилогдсон ажлын хэсэг багуудаас гарсан саналыг орон нутгийн хөгжлийн бодлоготой уялдуулан дүн шинжилгээ хийж, олонхийн санал авсан дарааллаар эрэмбэлэн сумын ИТХ-д өргөн мэдүүлжээ.

Баянгол сумын ИТХ-ын 2013 оны 1 дүгээр сарын 3-ны өдрийн 01 тоот тогтоолоор дээрх 23 төрлийн 280.8 сая төгрөгийн ажлыг баталсан боловч 2013 оны 12 дугаар сарын 19-ны өдрийн 36 тоот тогтоолоор 235.8 сая төгрөгийн төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр тодтогосон байна. Үүнийг хүснэгтээр харуулбал:

/ сая төгрөгөөр /				
№	Төсөл арга хэмжээний нэр	Саналын тоо /өрх /	төсөв	Тодотгосон төсөв
	Суманд хамааралтай ажил асуудлууд			
1	Сумын гэрэлтүүлгийг шинэчлэх, гэр хороололд гэрэлтүүлэг нэмж тавих	195	40.0	40.0
2	Сумын төвийн инженерийн шугам өргөтгөлийн зураг төсөв	129	20.0	20.0
3	Сурын талбайг тохижуулах	126	2.0	2.0
4	Сумын фондны өвс, тэжээлийн агуулах, хашаа барих	107	15.0	15.0
5	Мал угаалгын хуучин 2 ванныг сэргээх, засварлах 1 худаг гаргах	107	15.0	15.0
6	ХАА-н бүтээгдэхүүн борлуулах төв, халуун усны барилгын инженерийн шугам, төвийн худаг засвар	103	12.0	12.0
7	Мал үржлийн функтын багаж тоног төхөөрөмж худ/авах	87	7.0	7.0
8	Цэцэрлэгийн склад барих	79	20.0	20.0
9	Эмнэлгийн моргын тоног төхөөрөмж худалдан авах	76	10.0	10.0
10	Сургуулийн дотуур байрны цонхыг вакумжуулах	63	10.0	10.0
	Хараа баг			
11	Хустайд худаг гаргах	95	12.0	3.5
12	Дээжийн хэсэгт худаг гаргах	44	12.0	
13	Биеийн тамир, тоглоомын иж бүрэн талбайн тохижилт	40	10.0	10.0
14	Орон сууцны орчмын тохижилт	25	10.0	10.0
	Баян баг			
15	Төвийн гэр хорооллын хойд хэсэгт гүний худаг гаргах	59	15.0	
16	Хөдөөгийн хэсгийн Нарангийн орчимд гүний	59	12.0	2.5

	худаг гаргах			
17	Суварганы хашааг шинэчлэх, тохижуулах	49	10.6	10.6
18	Тоглоомын талбай барих /биеийн тамир/	28	5.0	5.0
19	Нарийн гудамжийг цементлэх	23	1.2	1.2
	Гонир			
20	Үерийн далан, сувгийн зураг төсөв хийлгэж ажлыг эхлүүлэх	65	15.0	15.0
21	Хүүхдийн тоглоомын талбай барих /биеийн тамир/	55	5.0	5.0
22	Гэр хорооллын усан хангамж төслийг үргэлжлүүлэх	24	10.0	10.0
23	Баянцогтод шинээр худаг гаргах	7	12.0	12.0
	Нийт дүн		280.8	235.8

Баянгол сумын болон аймгийн ОНХС-гаас эрх нь шилжсэн ажлуудаас сумын төвийн инженерийн шугам өргөтгөлийн зураг төсвөөс бусад ажил бүрэн хийгдсэн боловч сонгон шалгаруулалт болон ажлын гүйцэтгэлд дараах зөрчлүүд оршиж байна. Үүнд:

- Аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжсэн 40.0 сая төгрөгийн өртөг бүхий сургуулийн сантехник, ариун цэврийн өрөөний засвар, 30.0 сая төгрөгийн өртөг бүхий сумын төвийн инженерийн шугам засвар, сумын ОНХС-ын хөрөнгөөр хэрэгжүүлсэн 40.0 сая төгрөгийн өртөг бүхий гэрэлтүүлэг, 20.0 сая төгрөгийн өртөг бүхий цэцэрлэгийн склад барих зэрэг нийт 130.0 сая төгрөгийн ажлуудын тендерийн бичиг баримтыг боловсруулаагүй, гүйцэтгэгчийг харьцуулалтын аргаар сонгон шалгаруулалгүйгээр шууд гэрээ байгуулсан, ажлын явц, гүйцэтгэлд мэргэжлийн байгууллагаар хяналт тавиулаагүй,
- Иргэдийн бүлгээр 5 төрлийн 64.6 сая төгрөгийн ажлыг гүйцэтгүүлсэн боловч холбогдох журмын дагуу тендерийн баримт бичиг боловсруулаагүй, бүртгэлтэй иргэдэд үнийн санал хүргүүлж, харьцуулалтын арга хэрэглээгүй байв.

Дээрх байдлуудаас дүгнэхэд Баянгол сум нь ИНХ-ын ирц бүрдээгүй байхад хүчин төгөлдөр болсноор тооцож ОНХС-ийн хөрөнгөөр хийгдэх төсөл, арга хэмжээний саналыг авч эрэмбэлж, төлөвлөснөөс гадна хийгдсэн бүх ажлын гүйцэтгэгчийн сонгон шалгаруулалтыг огт явуулалгүйгээр шууд гэрээ байгуулан гүйцэтгүүлж, зарим ажлын явц, гүйцэтгэлд мэргэжлийн байгууллагаар хяналт тавиулаагүй байна.

Иймээс худалдан авах ажиллагааг хуулийн дагуу зохион байгуулаагүй Баянгол сумын Засаг дарга Б.Энхбатад хариуцлага тооцуулах албан шаардлагыг аймгийн Засаг дарга С.Бүрэнбатад хүргүүлэв.

Гурав. Алтанбулаг сум

1. Алтанбулаг сумын орон нутгийн хөгжлийн сан болон улс, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт, төсвийн санхүүжилтийг холбогдох хууль тогтоомжуудын дагуу зарцуулсан гэсэн:

1.1 Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалт, түүний зарцуулалтын байдал, үр ашиг, иргэдийн оролцооны талаар.

ОНХСангийн хөрөнгийг төлөвлөхдөө иргэдийн оролцоог хэрхэн хангасан талаар холбогдох баримт материалуудыг шалгаж үзэхэд:

2013 оны 1 дүгээр сарын 15-18-ны хооронд 1,2,3-р багийн ИНХ-ыг зохион байгуулсан бөгөөд МУ-ын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 23.10² дугаар зүйлд заасны дагуу ирц бүрдсэн тул хурлыг хүчин төгөлдөр болсноор тооцож, эрэмбэлж, баталсан саналыг сумын Засаг даргад хүргүүлснийг ажлын хэсэг нэгтгэн, эхний 15 санал тус бүр дээр ярилцан, 8 төсөл, арга хэмжээг сумын засаг даргын 2013 оны 1 дүгээр сарын 8 тоот захирамжаар ИТХ-д өргөн мэдүүлжээ.

Алтанбулаг сумын ИТХ-ын 2013 оны 11 тоот тогтоолоор дараах төсөл, арга хэмжээг ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэхээр эрэмбэлж баталсан байна.

№	Төсөл арга хэмжээний нэр	/сая төгрөгөөр/	
		Төсөвт өртөг	Авсан санал
1	Гүний худаг	50.0	169
2	Гэрэлтүүлэг	30.0	142
3	Цагдаагийн машин	15.0	126
4	Универсаль трактор	70.0	114
5	Зам талбайн тохижилт	10.7	84
6	Ногоон байгууламж	20.0	76
7	Алтанбулаг хаалга шинэчлэх	14.0	41
8	Хяраанд цахилгааны шугам татах	20.0	19
Нийт дүн		229.7	771

Аймгийн Аудитын газраас 2013 онд гүйцэтгэсэн “ОНХС-ийн төлөвлөлт, бүрдүүлэлт, зарцуулалтын үр нөлөөт байдал” сэдэвт гүйцэтгэлийн аудитаар цагдаагийн автомашин худалдан авах ажлыг удирдлагын зориулалттай болон улсын төсөвт байгууллагын зардал гэж үзэн ОНХС-гаас санхүүжүүлж болохгүй гэсэн учир иргэдээс дахин санал хурааж, сумын ИТХ-ын 2013 оны 33 тоот тогтоолоор сумын төвийг камержуулах хөрөнгө оруулалтын ажил болгон өөрчилсөн байна.

Сумын ОНХС-аар 2013 онд хэрэгжүүлсэн ажлын гүйцэтгэлд аудит хийхэд дараах зөрчлүүд илэрлээ. Үүнд:

1. Сумын ОНХС-ийн эх үүсвэрээр санхүүжүүлэхээр эрэмбэлсэн ажлын 4-т хог түрэх трактор 114 санал авч 70.0 сая төгрөг батлагдсан байна. Уг худалдан авалтын гүйцэтгэгчийг нээлттэй тендерээр сонгон шалгаруулах ёстой атал тендерийн бичиг баримт бэлдэлгүйгээр, МН өнөөдөр сонинд тендерийн урилга бус “Универсаль трактор худалдаж авна” гэсэн зарыг сумын төрийн сангийн төлөөлөгч Ц.Саранцэцэгийн нэр дээр өгч, 4 компани үнийн санал ирүүлснээс хамгийн бага үнийн санал ирүүлсэн гэж үзэн газар тариалан, мал аж ахуй, гадаад дотоод худалдаа эрхэлдэг Сэлэнгэ аймгийн Зүүнбүрэн сумын “Бат Сэлэнгэ” ХХК –ийг сонгон шалгаруулсан байгаа нь ТБОНӨХБАҮХА тухай хуулийн 8.2, 21.1, 21.5 дахь заалтуудыг тус тус зөрчсөн байна. Уг худалдан авалтын үнэлгээний хороонд мэдээлэлд дурдагдсан төрийн сангийн мэргэжилтэн Ц.Саранцэцэг оролцоогүй байна.
2. Оргидог булаг хэмээх газар цахилгаан татах 20.0 сая төгрөгийн нэмэлт ажил нь анхны гэрээний өртгөөс 15 хувиас дээш үнийн дүнтэй байхад дахин сонгон шалгаруулалт явуулалгүйгээр өмнөх гүйцэтгэгч “Ноён сайхан” ХХК-тай шууд гэрээ байгуулан гүйцэтгүүлсэн нь ТБОНӨХБАҮХА тухай хуулийн 33.1 болон

²Баг, хорооны Хурлын хуралдаанд зөвхөн тухайн баг, хорооны сонгуулийн насны иргэн бүр оролцож болох бөгөөд хуралдаанд багт 4 өрх тутмаас, хороо, аймгийн төвийн сумын багт 20-30 өрх тутмаас тус бүр нэг хүн хүрэлцэн ирсэн тохиолдолд хүчинтэйд тооцно.

34.1.4 дэхь заалтуудыг зөрчсөн байна. Уг худалдан авалтанд төрийн сангийн төлөөлөгч Ц.Саранцэцэг оролцоогүй бөгөөд сумын ЗДТГ-ын дарга Д.Түвшинбаяр захиалагчаар гэрээ байгуулжээ.

3. Гүний худаг гаргах 50.0 сая төгрөгийн ажил, Оргидог булагт цахилгаан татах 20.0 сая төгрөгийн ажилд ЗГ-ын 2012 оны 12 дугаар тогтоолоор батлагдсан “Барилгын ажлыг эхлүүлэх, үргэлжлүүлэх, ашиглалтанд оруулах дүрэм” 4.3 дахь заалтыг мөрдөөгүй, мэргэжлийн байгууллагаар хяналт тавиулаагүй байна.

Дээрх байдлуудаас дүгнэхэд Алтанбулаг сум нь ОНХС-ийн хөрөнгөөр хийгдэх төсөл, арга хэмжээг төлөвлөхдөө иргэдийн саналыг авсан боловч гүйцэтгэгчийн сонгон шалгаруулалтыг хуулийн дагуу зохион байгуулаагүй, зарим ажлын явц, гүйцэтгэлд мэргэжлийн байгууллагаар хяналт тавиулаагүй байна.

Иймээс ОНХС-гаар хийгдэх ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах, хяналт тавих үйл ажиллагаанд холбогдох хууль, дүрмийг мөрдөөгүй, хуулийн дагуу зохион байгуулаагүй худалдан авалтыг санхүүжүүлсэн төрийн албан хаагчдад сахилгын хариуцлага тооцуулах албан шаардлагыг сумын Засаг дарга Д. Сундуйд хүргүүлэв.

2. Улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт, төсвийн санхүүжилтийг зориулалтын дагуу зарцуулж байгаа эсэх?

2.1 Алтанбулаг сумын төрийн сангийн төлөөлөгч Ц.Саранцэцэг өөрийн хувьдаа унаж байгаад ашиглалтын хугацаа нь дууссан машинаа төсөвт шахсан, төсөвт авснаас хойш энэ машинд нийт хичнээн төгрөгөөр засвар үйлчилгээ хийсэн талаар?

Алтанбулаг сумын ЗДТГ нь хуулийн дагуу гүйцэтгэгчийг сонгон шалгаруулалгүйгээр сумын төрийн сангийн төлөөлөгч Ц.Саранцэцэгийн нөхөр П.Батсайханаас 1996 онд үйлдвэрлэгдсэн “Исузу Вигхорон” автомашиныг 10.0 сая төгрөгөөр 2007 оны 4 дүгээр сард шууд гэрээ байгуулан худалдан авсан нь ТБОНӨХБАҮХАТухай хуулийн 33.1 дахь заалт болон ЗГ-ын 2007 оны 42 дугаар тогтоолоор баталсан босго үнийг зөрчжээ.

Худалдах, худалдан авах гэрээнд тээврийн хэрэгслийн чанар, иж бүрдлийг “гадна үзэмж сайн, мотор хөдөлгүүр сайн, гэрэл дохио бүрэн, дотор салон сайн, 4 дугуй шинэ” гэж тодорхойлсон байна. Уг машинд хийсэн засвар үйлчилгээний зардлын талаар сумын ЗДТГ-ын нягтлан бодогч Н.Эрдэнэчимэгээс тодруулахад “2010 онд уг автомашины турбо нь эвдэрснийг иргэн П.Батсайхан өөрөө сэлбэг гарган зассан бөгөөд энэ машин нь одоо тус сумын Байгаль орчны албанд ашиглагдаж байгаа болно” гэсэн тодорхойлолтыг өглөө. Мөн 2007-2014 онуудад уг машиныг барьж байсан жолооч Чимэд-Очир, Амарсайхан зэрэг хүмүүсээс асуулга авахад турбо нь эвдэрч, засвар хийснээс өөр ямар нэгэн засвар хийгдээгүй гэсэн тайлбарыг өгч байна.

2.2 ТСТөлөөлөгч Ц.Саранцэцэг нь өөрийн нөхрийн “Алтанбилэг” ХХК-д сумын эмнэлгийн дээврийн засварын тендер, соёлын төвийн дээврийн засварын тендер, сургуулийн сурагчдын “Үдийн цай” хөтөлбөрийн тендер, сургуулийн гал тогоог шинээр тохижуулах тендер, сумын 64 айлын тохижилтын тендер, дулааны төвөөс сүм хүртэлх цэвэр, дулааны шугамыг шинэчлэн солих 150.0 сая төгрөгийн тендерийн ажлыг авч өгсөн эсэх?

Сумын эмнэлгийн дээврийн засварын 19.0 сая төгрөгийн өртөг бүхий ажлын тендерийн материалыг татан авч үзэхэд үнэлгээний хороо байгуулалгүйгээр, засаг даргын зөвлөлийн 2008 оны 10 дугаар сарын 13-ны өдрийн хурлаар гүйцэтгэгчийг

сонгон шалгаруулсан байна. Хуралд сумын Засаг дарга Д.Сундуй, засаг даргын орлогч В.Түмэндэмбэрэл, өрхийн аж ахуйн мэргэжилтэн Б.Буян-Өлзий, газрын даамал Н.Отгонцогт, төрийн сангийн төлөөлөгч Ц.Саранцэцэг, эрүүл мэндийн төвийн эрхлэгч Ц.Эрдэнэтуяа нар оролцож, үнийн санал ирүүлсэн “Талхун арал” ХХК, Дархан уул аймгийн иргэн Гансүх, “Алтанбилэг” ХХК дээр ярилцаж, төрийн сангийн төлөөлөгч Ц.Саранцэцэгийн гэр бүлийн хүний “Алтанбилэг” ХХК-г гүйцэтгэгчээр сонгон шалгаруулан 2008 оны 10 дугаар сарын 13-нд 003 тоот гэрээ байгуулжээ.

Аймгийн Хот байгуулалт, барилга захиалагчийн албатай 2008 оны 10 дугаар сарын 15-нд байгуулсан гэрээний үндсэн дээр явцын хяналт тавиулж, 2008 оны 11 дүгээр сарын 24-нд сумын комисс ажиллаж, уг ажлыг ашиглалтанд хүлээн авсан байна.

2008 онд ОНХО-аар хийгдэх Соёлын төвийн дээврийн засварын 10.0 сая төгрөгийн өртөг бүхий ажлын тендерийн материалыг үзэхэд үнэлгээний хороо байгуулсан болон гүйцэтгэгчийг сонгон шалгаруулсан тухай материал, ажил гүйцэтгэх гэрээ байхгүй байв. Харин сумын засаг даргын 2008 оны 8 дугаар сарын 12-ны 93 тоот захирамжаар сумын соёл, мэдээллийн төвийн дээврийн засварын ажилд хяналт тавих, үнэлэлт дүгнэлт өгөх, уг засварын ажлыг хүлээн авах комиссыг засаг даргын орлогч В.Түмэндэмбэрэл, төрийн сангийн төлөөлөгч Ц.Саранцэцэг, СМТ-ийн эрхлэгч Б.Оюунтуяа, БОУБайцаагч С.Мөнхзул, цахилгааны инженер Ж.Чимиддүрзээ гэсэн 6 хүний бүрэлдэхүүнтэй томилсон байна. Барилга байгууламжийг ашиглалтанд оруулах улсын комиссын актаас харахад уг ажлыг Алтанбилэг компани бус “Талхун арал” ХХК 8 дугаар сарын 3-аас 20-ын хооронд гүйцэтгэж, 2008 оны 8 дугаар сарын 28-ны өдрийн 21 тоот актаар улсын комисст хүлээлгэн өгчээ.

Алтанбулаг сумын ЕБС нь 2009 онд “Үдийн цай” хөтөлбөрийг хэрэгжүүлэхийн тулд хүнсний бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг хэд хэдэн компанид санал явуулахад Алтанбилэг компани л санал ирүүлсэн тул 2009 оны 9 дүгээр сарын 1-нд тус компанитай хамтран ажиллах гэрээ байгуулжээ.

Мөн сургуулийн гал тогооны тохижилтонд төсвийн хөрөнгө оруулалтаар ажил хийгдээгүй байна.

2010 онд “Тогтвортой амьжиргаа-2” төслийн хөрөнгөөр, 2008-2009 оны хичээлийн жилд Алтанбилэг ХХК нь өөрийн хөрөнгөөр сургуулийн гал тогоонд цэвэр усны шугам оруулж, цахилгааны монтажийг засварласан гэсэн тодорхойлолтыг Алтанбулаг сумын ерөнхий боловсролын сургуулийн захирал Б.Эрдэнэ-Очир албан тоотоор өглөө.

Энэ үйл ажиллагаанд сумын төрийн сангийн төлөөлөгч Ц.Саранцэцэг оролцоогүй байна.

Алтанбулаг сумын гудамж талбайн тохижилтын 12.0 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий ажлын гүйцэтгэгчийн сонгон шалгаруулалтыг 2011 оны 4 дүгээр сард зохион байгуулж, “Баян оргил хангай” ХХК, “Соёл” ХХК, “Сүрлэг харш” ХХК, “Алтанбилэг” ХХК, “Ган Норд” ХХК зэрэг 5 компанид урилга хүргүүлснээс “Баян-Оргил хангай”, “Алтанбилэг” компаниуд үнийн санал ирүүлжээ.

Алтанбулаг сумын Засаг даргын 2011 оны 4 дүгээр сарын 4-ны өдрийн 44 тоот захирамжаар ажлын хэсгийг 7 хүний бүрэлдэхүүнтэй байгуулсан байна. /ажлын хэсгийн ахлагчаар засаг даргын орлогч В.Түмэндэмбэрэл, нарийн бичгийн даргаар төрийн сангийн төлөөлөгч Ц.Саранцэцэг, гишүүдээр газрын даамал, хууль эрх зүйн ажилтан, 1,2-р багийн засаг дарга, ХАА-н тасгийн дарга зэрэг/ Тендерийг 2011 оны 4 дүгээр сарын 13-

нд нээх гэсэн боловч 2 компани материал ирүүлсэн учир хангалтгүй гэж үзэн, материал хүлээн авах хугацааг 4 дүгээр сарын 15-ны 11 цаг хүртэл сунгажээ.

Сонгон шалгаруулалтанд Ц.Саранцэцэгээс бусад гишүүд оролцож, нэмж материал ирээгүй тул өмнөх 2 компаний материалыг задлан, 7.0 сая төгрөгийн үнийн санал ирүүлсэн “Алтанбилэг” ХХК-г гүйцэтгэгчээр сонгон шалгаруулан 64 айлын орон сууцны тохижилтын ажлыг гүйцэтгүүлсэн байна.

2011 оны 5 дугаар сарын 25-ны 001 тоот актаар “Алтанбилэг” компаний хийсэн тохижилтын ажлыг, 002 тоот актаар сургууль, ЭМТ, 2 цэцэрлэг, ЗДТГ, Соёлын төвийн тохижилтын ажлыг сумын комисс ашиглалтанд хүлээн авчээ.

Алтанбулаг сумын дулааны шугамыг шинэчлэн солих ажлын тендерийн материалыг татан авч үзэхэд:

Тус ажилд аймгийн хөрөнгө оруулалтаар 2011 онд 50.0 сая төгрөг, 2012 онд 100.0 сая төгрөг тус тус батлагдсан байна.

2011 оны дулааны шугамыг шинэчлэн солих 50.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй ажлын гүйцэтгэгчийг харьцуулалтын аргаар сонгон шалгаруулж, аймгийн төвийн “Миний монгол” телевизээр зар явуулахад 4 компани тендерийн баримт бичиг авснаас “Батсэлэнгэ” ХХК 116.6 сая төгрөгөөр, “Алтанбилэг” ХХК 49.6 сая төгрөгөөр гүйцэтгэх үнийн санал ирүүлжээ.

Алтанбулаг сумын Засаг даргын 2011 оны 5 дугаар сарын 75 тоот захирамжаар ажлын хэсгийг 5 хүний бүрэлдэхүүнтэй байгуулсан байна. *Ажлын хэсгийн ахлагчаар засаг даргын орлогч В.Түмэндэмбэрэл, нарийн бичгийн даргаар төрийн сангийн төлөөлөгч Ц.Саранцэцэг, гишүүдээр газрын даамал Н.Отгонцогт, хууль эрх зүйч Б.Батзориг, байгаль хамгаалагч О.Отгонтөгс нар /*

2011 оны 5 дугаар сарын 30-нд ажлын хэсэг хуралдаж, гүйцэтгэгчээр “Алтанбилэг” ХХК-г сонгон шалгаруулжээ. Ажлын хэсгийн нарийн бичгийн даргаар томилогдсон төрийн сангийн төлөөлөгч Ц.Саранцэцэг өргөдөл гаргаж, гэр бүлийн хүнийх нь компани энэ сонгон шалгаруулалтанд оролцож байгаа учир санал өгөх эрхгүйгээр, хурлын тэмдэглэл хөтөлсөн байна.

“Алтанбилэг” ХХК 49.6 сая төгрөгөөр хийхээр үнийн санал ирүүлсэн боловч техник хяналтын зардлыг оруулаад нийт 50.0 сая төгрөгөөр ажил гүйцэтгэх гэрээг байгуулжээ. Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газартай гэрээ байгуулж, явцын хяналтыг тавиулан, гүйцэтгэлийг ил, далд ажлын акт, фото зургаар баримтжуулсан байна. Дулааны шугамын засварын ажлыг 2011 оны 12 дугаар сарын 12-нд хүлээн авчээ.

2012 оны аймгийн хөрөнгө оруулалтаар хийгдэх, дулааны шугамыг шинэчлэн солих 50.0 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий ажлын гүйцэтгэгчийг харьцуулалтын аргаар сонгон шалгаруулахаар “Тэнгэрийн цагаан хүлэг”, “Сэлэнгэ принтинг”, “Сэлэнгэ таван хан”, “Алтанбилэг” зэрэг 4 компанид урилга хүргүүлснээс “Алтанбилэг” ХХК 50.0 сая төгрөг, “Тэнгэрийн цагаан хүлэг” ХХК 50.1 сая төгрөг, “Сэлэнгэ принтинг” ХХК 51.9 сая төгрөгөөр гүйцэтгэхээр үнийн санал ирүүлсэн байна.

Алтанбулаг сумын Засаг даргын 2012 оны 3 дугаар сарын 24 тоот захирамжаар уг худалдан авалтыг зохион байгуулах ажлын хэсгийг 5 хүний бүрэлдэхүүнтэй байгуулжээ. *Даргаар засаг даргын орлогч В.Түмэндэмбэрэл, нарийн бичгийн даргаар төрийн сангийн төлөөлөгч Ц.Саранцэцэг, гишүүдээр газрын даамал Н.Отгонцогт, байгаль хамгаалагч С. Мөнхзул, хууль эрх зүйч Б.Батзориг зэрэг /*

Ажлын хэсэг 2012 оны 3 дугаар сарын 26-нд хуралдаж, “Алтанбилэг” ХХК-г гүйцэтгэгчээр сонгон шалгаруулан 2012 оны 4 дүгээр сарын 2-нд ажил гүйцэтгэх гэрээ байгуулсан бөгөөд ажлын хэсгийн нарийн бичгийн даргаар томилогдсон төрийн сангийн төлөөлөгч Ц.Саранцэцэг өргөдөл гаргаж, санал өгөх эрхгүйгээр хурлын тэмдэглэлийг хөтөлсөн байна.

2012 оны 4 дүгээр сард хийгдсэн дээрх ажлаас өмнө буюу 2012 онын 2 дугаар сард Алтанбулаг сумын сургуулийн дулааны шугам хагарч, эвдрэл нь олдохгүй, гамшгийн байдал үүссэн учир “Алтанбилэг” ХХК 100 м газарт өөрийн хөрөнгөөр ил шугам тавьсан байна. 2012 оны 3 дугаар сард аймгийн төсвийн тодотголоор дээрх гэмтэл гарсан шугамыг оролцуулан сургууль хүртэлх шугамыг засах ажилд дахин 50,0 сая төгрөг батлагдсан тул энэ ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулалт хийлгүйгээр өнгөрсөн өвөл нь буюу 2 дугаар сард хагарсан шугамыг өөрийн хөрөнгөөр засварласан “Алтанбилэг” ХХК-тай шууд гэрээ байгуулан гүйцэтгүүлжээ.

Шууд гэрээ байгуулсан үндэслэлээ ТБОНӨХБАҮХАТ хуулийн 34.1.5 дахь “Гэнэтийн болон давагдашгүй хүчний шинжтэй онцгой нөхцөл байдлын улмаас нээлттэй буюу хязгаарлагдмал тендер шалгаруулалтын журмын дагуу тендер хүлээн авах доод хугацааг мөрдөх боломжгүй бол гэрээ шууд байгуулах аргыг хэрэглэнэ” гэсэн заалтыг мөрдсөн гэж тайлбарлаж байлаа.

2 дугаар сард халаалт дулааны шугаманд эвдрэл гарч онцгой нөхцөл байдал үүсэхэд дулаан түгээх гэрээтэй “Алтанбилэг” компани өөрийн хөрөнгөөр шугаманд засвар үйлчилгээ хийсэн нь 4 сард сонгон шалгаруулалт зарлагдаж, гүйцэтгэгдэх шугамын засварын ажлыг шууд гэрээгээр гүйцэтгэх ТБОНӨХБАҮХАТХ хуулийн 34.1.5 –д заасан үндэслэл болж чадахгүй, өөрөөр хэлбэл 50.0 сая төгрөгийн өртөг бүхий ажлын гүйцэтгэгчийг хуулийн дагуу сонгон шалгаруулаагүй гэж үзэж байна.

Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газартай 2012 оны 6 дугаар сарын 18-ны өдрийн ТХ-28/2012 тоот гэрээгээр 2012 онд хийгдсэн 2 удаагийн нийт 100.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй дулааны шугамын засварын ажилд хяналт тавих гэрээг байгуулж, явцын хяналтыг тавиулан, гүйцэтгэлийг ил далд ажлын ажлын акт, фото зургаар баримтжуулсан байна. Дулааны шугамын засварын ажлыг 2012 оны 12 дугаар сарын 27-ны 18-17-25/28 тоот актаар улсын комисс хүлээн авчээ.

Алтанбулаг сумын иргэн В.Ганболд нь 2013 оны 3 дугаар сард “Дулааны төвөөс сүм хүртэлх цэвэр ус, дулааны шугамыг шинэчлэн солихоор 2011-2012 онуудад хийгдсэн дээрх 150.0 сая төгрөгийн ажлын сонгон шалгаруулалтыг сумын төрийн сангийн төлөөлөгч Ц.Саранцэцэг, засаг даргын орлогч В.Түмэндэмбэрэл нар зохих хуулийн дагуу явуулалгүйгээр төрийн өмчийг их хэмжээгээр хувьдаа завшсан” хэмээн гомдол гаргасныг Сэлэнгэ аймгийн Прокурорын газар шалгаж үзээд 2013 оны 7 дугаар сарын 15-ны өдрийн 106 дугаар тогтоолоор, нотлох баримтаар тогтоогдоогүй гэсэн үндэслэлээр хэрэгсэхгүй болгожээ.

Иргэдийн гаргасан өргөдөлд бичсэнчлэн тус суманд улс, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт, ОНХС-гаар хэрэгжсэн бараг бүх ажлын гүйцэтгэгчийн сонгон шалгаруулалтанд “Алтанбилэг” компани оролцоогүй бөгөөд 2007 оны автомашин худалдан авах, 2008 оны ЭМТөвийн дээврийн засварын ажил, 2011 оны 64 айлын тохижилтын ажилд л Алтанбилэг компаний захирал П.Батсайханы гэр бүлийн хүн, сумын төрийн сангийн төлөөлөгч Ц.Саранцэцэг оролцсон байна.

ОНХС-гаар хэрэгжсэн трактор худалдан авах, 2012 оны дулааны шугамын засварын 50.0 сая төгрөгийн өртөг бүхий тендерийн ажлын гүйцэтгэгчийг хуулийн

дагуу сонгон шалгаруулаагүй үнэлгээний хорооны, ажлын хэсгийн гишүүдэд хариуцлага тооцох албан шаардлагыг сумын Засаг дарга Д.Зундуйд хүргүүлэв.

Иргэдийн гаргасан өргөдөлд бичсэнчлэн тус суманд улс, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт, ОНХС-гаар хэрэгжсэн бараг бүх ажлын гүйцэтгэгчийн сонгон шалгаруулалтанд Алтанбилэг компани оролцож байхад тус компаний захирал П.Батсайханы гэр бүлийн хүн, сумын төрийн сангийн төлөөлөгч Ц.Саранцэцэгийг үнэлгээний хороо, ажлын хэсэгт томилон ажиллуулж буй зөрчлийг арилгах болон хөрөнгө оруулалтаар хийгдсэн ажлуудын гүйцэтгэгчийг хуулийн дагуу сонгон шалгаруулаагүй үнэлгээний хороо, ажлын хэсгийн гишүүдэд хариуцлага тооцох албан шаардлагыг сумын Засаг дарга Д.Сундуйд хүргүүлэв.

3. Орон нутгийн өмчийн хувьчлал хууль, журмын дагуу явагдсан эсэх?

3.1 Алтанбулаг сумын “Халаалтын төв”-ийн барилгын хувьчлал хууль, журмын дагуу явагдсан уу?

Алтанбулаг сумын “Халаалтын төв”-ийн хувьчлалын баримтыг аймгийн Орон нутгийн өмчийн албанаас авч үзэхэд:

Сэлэнгэ аймгийн ИТХ-ын 2006 оны 12 дугаар сарын 128 дугаар тогтоолоор “Алтанбулаг сумын төвд байрлалтай, 1970 онд ашиглалтанд орсон, ашиглалтын хугацаа дуусаж, чанар байдлаа алдаж тоногдсон, ашиглалтгүй байгаа халаалтын төвийн хуучин барилга”-ыг дуудлага худалдаагаар худалдахаар шийдвэрлэж, дуудлага худалдааны доод үнийг 2.0 сая төгрөгөөр тогтоожээ. Дуудлага худалдаа 2007 оны 1 дугаар сарын 12-ны өдөр зохион байгуулагдаж, 2.0 сая төгрөгөөр иргэн П.Батсайхан худалдаж авсан нь мөнгө тушаасан баримт болон 2007 оны 1 дүгээр сарын 12-ны өдрийн 04 тоот худалдах, худалдан авах гэрээнээс харагдаж байна.

Хэдийгээр уг барилгын чанар муудсан боловч барилгын тал хэсэгт нь халаалтын төв үйл ажиллагаагаа хэвийн явуулж, жил бүр менежментийн гэрээгээ сунган ажиллаж байхад аймгийн ИТХ-ын 2006 оны 128 дугаар тогтоолд халаалтын төвийн барилгыг тоногдсон, ашиглалтгүй байгаа гэж заан дуудлага худалдаагаар худалдах шийдвэр гаргасан байгаа нь бодит байдалтай нийцэхгүй байгаа бөгөөд барилгыг нь худалдчихаад сумын төвийн халаалт, дулааны асуудлыг хэрхэн хангах тухай шийдвэр гаргаагүй байна.

Энэ талаар сумын засаг дарга Д.Сундуйгаас тодруулга авахад *“Уг барилгыг дуудлага худалдаагаар худалдах талаар сумаас ямар ч санал аваагүй, дуудлага худалдаагаар худалдсан болохыг бид сүүлд нь мэдэж сумын төвийн халаалт, дулааны асуудлыг шийдвэрлэхийн тулд “Алтанбилэг” ХХК-тай гэрээ байгуулан өнөөг хүртэл хамтран ажиллаж байна”* гэж байлаа.

“Алтанбулаг итгэл” ТББ-ын захирал Ц.Болормаа нь Алтанбулаг сумын халаалтын төвийн барилгын дуудлага худалдааг хүчингүй болгуулах хүсэлтийг ТӨХ-нд хүргүүлсний дагуу холбогдох материалтай нь танилцаж үзээд 2014 оны 3 дугаар сарын 26-ны өдрийн 18/848 тоот албан бичгээр *“ тус барилгын хувьчлалтай холбоотой баримт архивт хангалттай хэмжээнд хадгалагдаж үлдээгүй бөгөөд Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 6 дугаар бүлгийн 39.1 дэх заалтыг зөрчсөн нь ИТХ-ын тэргүүлэгчдийн шийдвэр гарсан хугацаа, дуудлага худалдааг зохион байгуулсан хугацаанаас нотлогдож байна. Иймд холбогдох шатны шүүхэд хандан дуудлага худалдааг хүчингүй болгох асуудлаа шийдвэрлүүлэх хэрэгтэй”* гэсэн зөвлөмжийг өгчээ.

Аймгийн Орон нутгийн өмчийн алба болон архивт байгаа Алтанбулаг сумын “Халаалтын төв”-ийн барилгын хувьчлалын баримтуудаас үзэхэд:

- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77.3³-д заасны дагуу Төрийн өмчийн хороотой зөвшилцсөн эсэх нь тодорхойгүй
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 35.1 дэх заалтын дагуу төрийн өмчийн эд хөрөнгийг хувьчлахын өмнө эд хөрөнгийн тооллого, үнэлгээ хийж, ТӨХ-ны итгэмжлэгдсэн төлөөлөгчийн хяналтанд шилжүүлсэн эсэх нь тодорхойгүй
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 39,1⁴ дэх заалтыг зөрчиж дуудлага худалдааг зохион байгуулсан, сонин хэвлэлд өгсөн зар байхгүй
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 41 дүгээр зүйлд заасан дуудлагын хуралдаанд оролцогчдын бүртгэл, дуудлагын хуралдааны явцын тэмдэглэл байхгүй
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 65 дугаар зүйлд заасны дагуу хувьчлалыг эрхлэн явуулсан албан тушаалтан хувьчлалын тайлан бичиж, ТӨХ-ны хуралдаанд оруулан, батлуулсны дараа архивт хүлээлгэн өгөх ёстой боловч эдгээр нотлох баримтууд байхгүй байлаа.

Тухайн үед аймгийн ИТХ-ын дарга, нарийн бичгийн дарга, Орон нутгийн өмчийн албаны даргаар ажиллаж байсан хүмүүс нь өндөр насны тэтгэвэрт суусан учир асуулга авах боломжгүй байв.

3.2 Сэлэнгэ аймгийн Орон нутгийн судлах “Музей”-г хууль бусаар хувьчилж авсан уу?

Аймгийн ИТХ-ын 2006 оны 04 тоот тогтоолоор “1954 онд ашиглалтанд орсон аймгийн орон нутгийн судлах музейн чулуун барилгыг дуудлага худалдаагаар худалдах”-аар шийдвэрлэж, дуудлага худалдааны доод үнийг 3.1 сая төгрөгөөр тогтоожээ. Дуудлага худалдааг 2006 оны 2 дугаар сарын 6-нд зохион байгуулж, 6.6 сая төгрөгөөр иргэн П.Батсайхан худалдан авсан нь мөнгө тушаасан баримт, 2006 оны 2 дугаар сарын 6-ны өдрийн 14 тоот худалдах, худалдан авах гэрээнээс харагдаж байна.

Орон нутгийн өмчийн алба болон аймгийн архивт байгаа Орон нутгийн судлах музейн барилгын хувьчлалын баримтуудаас үзэхэд:

- Төрийн өмчийн хороотой зөвшилцсөн эсэх нь тодорхойгүй
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 35.1 дэх заалтын дагуу төрийн өмчийн эд хөрөнгийг хувьчлахын өмнө эд хөрөнгийн тооллого, үнэлгээ хийж, ТӨХ-ны итгэмжлэгдсэн төлөөлөгчийн хяналтанд шилжүүлсэн эсэх нь тодорхойгүй
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 36.1 дэх заалтын төр засгийн албан ёсны хэвлэл, мэдээллийн хэрэгслээр нийтэд сонордуулсан эсэх нь тодорхойгүй
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 41 дүгээр зүйлд заасан дуудлагын хуралдаанд оролцогчдын бүртгэл, дуудлагын хуралдааны явцын тэмдэглэл байхгүй
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 65 дугаар зүйлд заасны дагуу хувьчлалыг эрхлэн явуулсан албан тушаалтан хувьчлалын тайлан бичиж, ТӨХ-ны хуралдаанд оруулан, батлуулсны дараа архивт хүлээлгэн өгөх ёстой боловч эдгээр нотлох баримтууд байхгүй байна.

³Орон нутгийн өмчийн үндсэн хөрөнгийг хувьчлах ба бусдад шилжүүлэх... хувьчлах эд хөрөнгийн жагсаалтыг батлахдаа Төрийн өмчийн хороотой зөвшилцөнө

⁴Дуудлага худалдааг явуулах зар мэдээг ТӨХ энэхүү ажиллагааг явуулахаас товлосон өдрөөс 30-аас доошгүй хоногийн өмнө мэдээлнэ.

- Тухайн үед аймгийн ИТХ-ын дарга, нарийн бичгийн дарга, Орон нутгийн өмчийн албаны даргаар ажиллаж байсан хүмүүс өндөр насны тэтгэвэрт суусан.

Иймд аймгийн Аудитын газар нь Алтанбулаг сумын “Халаалтын төв”-ийн болон аймгийн төвд байрлах Орон нутгийн судлах музейн барилгын дуудлага худалдаа үнэн зөв явагдсан талаар дүгнэлт гаргах боломжгүй тул ТӨХ-ны 2014 оны 18/848 тоот албан бичгийн дагуу холбогдох шатны шүүхэд хандах нь зүйтэй гэж үзэж байна.

4. “Алтанбилэг” ХХК нь Эрчим хүчний тухай хуулийн дагуу “дулаан үйлдвэрлэх”, “дулаанаар зохицуулалттай хангах” тусгай зөвшөөрлийн дагуу айл өрх, албан байгууллагыг дулаанаар хангах үйл ажиллагаа эрхлэх албан ёсны эрхтэй эсэх ?

Алтанбулаг сумын халаалтын төвийн барилгыг дуудлага худалдаагаар худалдан авсан “Алтанбилэг” ХХК-ний захирал П.Батсайхан нь 2003 оноос хойш тус халаалтын төвд ажиллаж байсан бөгөөд сумын Засаг даргын 2004 оны 5 дугаар сарын 21-ний 41 тоот захирамжаар халаалтын төвийн даргаар томилогдсон байна.

Тус халаалтын төв нь цахилгаан, НДШ, цалин зэрэг нийт 27.8 сая төгрөгийн өртэй болж цаашид ийм байдлаар ажиллах боломжгүй болсон учир халаалтын төвийг аж ахуйн тооцоотой, менежментийн хувьчлалын гэрээгээр ажиллуулах болж сумын ЗДТГ-ын дарга Д.Түвшинбаяр, халаалтын төвийн дарга П.Батсайхан нар 2004 оны 10 сард гэрээ байгуулжээ. Менежментийн гэрээгээр ажилласан хугацаанд нийт өрөөс 10.5 саяыг барагдуулж, үйл ажиллагааг хэвийн явуулж байгаа гэж үзэн менежментийн хувьчлалын гэрээг 2005 оны 4 дүгээр сарын 13-нд нэг жилийн хугацаагаар шинэчлэн байгуулсан байна. Ингэж халаалтын төвийг менежментийн хувьчлалын гэрээгээр ажиллуулж байгаад Сэлэнгэ аймгийн ИТХ-ын 2006 оны 12 сарын 128 дугаар тогтоолоор “Алтанбулаг сумын төвд байрлалтай, 1970 онд ашиглалтанд орсон, ашиглалтын хугацаа дуусаж, чанар байдлаа алдаж тоногдсон, ашиглалтгүй байгаа халаалтын төвийн хуучин барилгыг дуудлага худалдаагаар худалдахаар шийдвэрлэсний дагуу дуудлага худалдаа 2007 оны 1 дүгээр сарын 12-ны өдөр зохион байгуулагдаж, 2.0 сая төгрөгөөр иргэн П.Батсайхан худалдаж авсан байна. /Дуудлага худалдааны талаар дээрх бүлэгт тусгасан болно /

П.Батсайхан нь халаалтын төвийн барилгыг дуудлага худалдаагаар худалдан аваад тус халаалтын төвийн эрхэлж байсан, тусгай зөвшөөрөл бүхий дулаан үйлдвэрлэх, түгээх, цэвэр усаар хангах, бохирыг зайлуулах үйл ажиллагаануудыг өөрийн “Алтанбилэг” ХХК-ний нэр дээр үргэлжлүүлэн гүйцэтгэж иржээ. Барилгыг хувьчлаагүй байхад халаалтын төвд ашиглагдаж байсан төхөөрөмжүүд, худаг, шугам хоолойнуудаас гадна өөрийн хөрөнгөөр ихээхэн хэмжээний тоног төхөөрөмжүүдийг бэлтгэн үйл ажиллагаа явуулж байна.

Хувьчлагдсан барилгыг П.Батсайханд хүлээлгэн өгөхдөө халаалтын төвд ашиглагдаж байсан төхөөрөмжүүдийг салгаагүй, өөрөөр хэлбэл хаана ч бүртгэлгүй хөрөнгүүдийн ашиглах боломжтойг нь “Алтанбилэг” компани ашиглаж, хуучирч муудсан, ашиглах боломжгүй нь хадгалагдаж байна. /П.Батсайханыг халаалтын төвийн даргаар томилогдоход хүлээн авсан хөрөнгийн жагаалтыг хавсаргаав/

Хэдийгээр эдгээр хөрөнгүүд нь элэгдэж муудсан ч гэсэн анхны баримттай нь тулгаж, орон нутгийн өмчид бүртгэх албан шаардлагыг сумын Засаг дарга Д.Сундуй, ЗДТГ-ын нягтлан бодогч Н.Эрдэнэцэцэг нарт хүргүүлэв.

МУ-ын Эрчим хүчний тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1-д заасны дагуу “Алтанбилэг” ХХК нь дулаан үйлдвэрлэх, дулаанаар зохицуулалттай хангах гэсэн

тусгай зөвшөөрөлтэй байх ёстой бөгөөд эдгээр тусгай зөвшөөрлүүдийг авсан эсэх талаар “Алтанбилэг” ХХК-ний захирал П.Батсайханаас асуухад:

“Аймгийн ЭХЗЗ-өөс 2006 онд “Дулаан үйлдвэрлэх болон дулаан түгээх “ 005 дугаартай тусгай зөвшөөрлийг 5 жилийн хугацаатай авч, 2012 онд сунгалт хийлгэх хүсэлт тавин холбогдох баримт материалыг бүрдүүлэн өгсөний үндсэн дээр 53/12 дугаартай “Дулаан үйлдвэрлэх”, 54/12 дугаартай

“Дулаанаар зохицуулалттай хангах” гэсэн тусгай зөвшөөрлүүдийг 5 жилийн хугацаатай авч үйл ажиллагаа явуулж байна. Иргэн Болормаа нь манай компанийг тусгай зөвшөөрөлгүйгээр, өөрөөр хэлбэл хуурамч тусгай зөвшөөрлөөр дулаан үйлдвэрлэх, түгээх үйл ажиллагаа эрхэлж байгаа гэж шүүхэд нэхэмжлэл гаргасны дагуу тусгай зөвшөөрлийн эх гэрчилгээг нотлох баримтаар шүүх татан авсан болно” гээд, бидэнд хуулбар хувийг үзүүлсэн болно.

Алтанбулаг сумын иргэн Ц. Болормаа нь Захиргааны хэргийн анхан шатны 6 дугаар шүүхэд “Алтанбилэг” компанид олгосон 2006 оны “дулаан үйлдвэрлэх болон дулаан түгээх 005 дугаартай, мөн 2012 оны “дулаан үйлдвэрлэх” 53/12 дугаартай, “дулаанаар зохицуулалттай хангах” 54/12 дугаартай тусгай зөвшөөрлийг тус тус хүчингүй болгуулахыг хүссэн нэхэмжлэл гаргасныг хянан үзээд 2014 оны 3 дугаар сарын 21-ний өдрийн 19 дүгээр шийдвэрээр үндэслэлгүй гэж бүхэлд нь хэрэгсэхгүй болгожээ.

Иргэн Ц.Болормаа нь дээрх шийдвэрийг эс зөвшөөрч Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхэд нэхэмжлэл гаргасныг хянан үзээд 2014 оны 5 дугаар сарын 21-ний өдрийн 193 тоот магадлалаар “нэхэмжлэгчийн маргаж байгаа айл өрх, албан байгууллага, иргэдийг хангах, дулаанаа чанаргүй нийлүүлснээс байр хөлдөөсөн, мөнгө төлөхтэй холбоотой асуудал нь Эрчим хүчний тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.1-д зааснаар дулаанаар хангах байгууллага болон иргэдийн хооронд байгуулах гэрээгээр зохицуулагдах асуудал байна”, “нэхэмжлэгч нь “Алтанбилэг” ХХК-ийн үйл ажиллагаатай холбогдуулан маргаж байгаа тул хувийн хуулийн этгээдийн үйл ажиллагаатай холбоотой гомдлыг иргэний хэргийн шүүхэд гаргах нь зүйтэй”, нэхэмжлэгчийн эрхийг зөрчиж байгаа гэх этгээд нь захиргааны байгууллага биш, “Алтанбилэг” ХХК-ийн үйл ажиллагаа, тэр дундаа дулаанаар хангах үйл ажиллагаатай холбогдуулан маргаж байгаа тул захиргааны хэргийн шүүхийн шийдвэрлэх маргаан биш байна” гэж үзээд захиргааны хэргийн анхан шатны шүүхийн шийдвэрийг хүчингүй болгож, хэргийг хэрэгсэхгүй болгон нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзсан байна.

“Алтанбилэг” компаний дулаан үйлдвэрлэх, дулаанаар зохицуулалттай хангах тусгай зөвшөөрөл нь хуурамч эсэх, түүнийг хүчингүй болгох асуудал нь төрийн аудитын байгууллагын чиг үүрэгт хамааралтай биш харин шүүхийн байгууллагын шийдвэрлэх асуудал тул Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн гаргасан магадлалын дагуу хүсэлтээ иргэний хэргийн шүүхэд гарган шийдвэрлүүлэх нь зүйтэй гэж үзэж байна.

ШАЛГАСАН:АУДИТОР

Ц.ОТГОНБАЯР

ХЯНАСАН:ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ч.ЭНХТУЯА

Хавсралт 1

Баянгол сумын ИТХ-ын Тэргүүлэгчдийн
2013 оны 09 сарын 04-ны өдрийн
36 тоот тогтоолын хавсралт

	Хадлангийн талбайн суурь үнэлгээ	Итгэлцүүр	1 га-ийн үнэлгээ /хуучин/	1 га-ийн үнэлгээ
Өөрийн сумын малчин, мал бүхий иргэдэд ашиглуулах хадлангийн талбай	2478.3	0.01-0.03	500	1000
Өөрийн сумын бизнесийн чиглэлээр хадлан өвс бэлтгэгчдэд ашиглуулах хадлангийн талбай	2478.3	0.01-0.03	750	1800
Бусад сумын иргэн ААН, байгууллагад ашиглуулах хадлангийн талбай	2478.3	0.01-0.03	1400	2500